

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгосон 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцгийн халамжийн тэтгэвэр авах эрхийг тухайн эрх дуусгавар болох хүртэл хугацаанд хэвээр хадгална.

2 дугаар зүйл. 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас ахмад настны тэтгэвэр тогтоолгосон хүний халамжийн тэтгэвэр авах эрхийг тухайн эрх дуусгавар болох хүртэл хугацаанд хэвээр хадгална.

3 дугаар зүйл. 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийг сунгах эсхүл дахин магадлах хүртэлх хугацаанд эрхийг хэвээр хадгална.

4 дүгээр зүйл. 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө сум, хорооны халамжийн нийгмийн ажилтнаар ажиллаж байсан төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 29.1 дэх хэсгийн Нийгмийн ажлын мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх гэсэн нөхцөл хамаарахгүй.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан мэргэжлийн хамтарсан зөвлөл байгуулан ажиллах, бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх, хэрэгцээг тодорхойлж, асаргааны тэтгэмж, халамжийн үйлчилгээ, дэмжлэг, тусламж, хөнгөлөлтөд хамруулах зохицуулалтыг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх бөгөөд энэ хугацаанд ахмадын эсхүл сэргээн засалтын эмч, согог зүйч, хөдөлгөөн засалч, хэл засалчийг бэлтгэх ажлыг Нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагууд хамтран зохион байгуулна.

6 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан асаргаа шаардлагатай хүнийг тогтоох, асаргааны тэтгэмж, халамжийн үйлчилгээ, дэмжлэг, тусламж,

хөнгөлөлтөд хамруулах зохицуулалтыг 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн дагуу 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл.2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.10-т заасан сургалтыг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйл болон 6 дугаар зүйлийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 19 дүгээр зүйлийн 19.16, 19.23, 25 дугаар зүйлийн 25.2, 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.9 дэх хэсэгт заасан дүрэм, аргачлал, журмыг тус тус 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

11 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 4.1.14, 4.1.15, 4.1.16, 4.1.17 дахь хэсэг:

“4.1.14.“бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын үйлдэл, үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадамжийн түвшнийг тодорхойлж, тулгамдсан асуудал, хэрэгцээг эрэмбэлэн тогтоох үйл ажиллагааг.

4.1.15.“туслах бүтээгдэхүүн” гэж биеийн гадна хэсэгт болон хүний биед суулгаж, өдөр тутмын амьдралдаа хэвийн оролцоход нь туслах, чадвараа ахиулахад тухайн хүнд нь тохируулж онцгойлон үйлдвэрлэдэг эсвэл нийтэд зориулсан бүтээгдэхүүн (хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж)-ийг;

4.1.16.“нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалт” гэж Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас батласан “Нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүн”-ий жагсаалтад үндэслэн, үйл ажиллагааны алдагдалтай хүнд хэрэглэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газраас баталсан туслах бүтээгдэхүүний нэрсийг;

4.1.17.”урт хугацааны сэргээн засах үйлчилгээ” гэж хүний бие бялдар, сэтгэл зүй, мэдрэхүй, танин мэдэхүй болон нийгмийн оролцооны алдагдсан эсвэл буурсан чадварыг сэргээх, хадгалах, сайжруулах зорилгоор урт хугацаанд тасралтгүй үзүүлдэг эрүүл мэнд, нийгэм, боловсрол болон дэмжих цогц үйлчилгээг.”

2/21 дүгээр зүйлийн 21.2, 21.3, 21.4, 21.5, 21.6, 21.7, 21.8 дахь хэсэг:

“21.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүн нь хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд таарахгүй болсон болон эдэлгээний хугацаа дууссан тохиолдолд зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу бүрэн эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх;

21.3.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу

протез, ортопедийн зардлын төлбөрийг авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан өндөр болон зарим дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлт, түрээсийн төлбөрийн зарим хэсгийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу хэсэгчлэн санхүүжүүлэх;

21.4.Эмнэлгийн хэрэглэгдэхүүнээс бусад нэн шаардлагатай туслах хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн зардлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусган, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас баталсан жагсаалт, олгох давтамж, жишиг үнийг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд нөхөн олгох.

21.5.Энэ хуулийн 21.2, 21.3, 21.4-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүнийг гадаад улсад хийлгэсэн эсхүл худалдан авсан бол түүний зардлын төлбөрийг энэ хуулийн 21.2, 21.3, 21.4-т заасан дотоодод хийлгэсэн жишиг үнийг баримтлан нөхөн олгож болно.

21.6.Энэ хуулийн 21.2, 21.3-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр нийгмийн халамжийн сангаас Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлнэ.

21.7.Энэ хуулийн 21.2, 21.3-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр үйлчлэх, олгох журмыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батална.

21.8.Энэ хуулийн 21.4-т заасан нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, түрээслэх, олгох, тохируулах, сургалт зөвлөгөө өгөх журмыг Засгийн газар батална.”

3/26 дугаар зүйлийн 26.5, 26.6, 26.7, 26.8 дахь хэсэг:

“26.5.Энэ хуулийн 26.1.17, 26.8-д заасан үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.6.Энэ хуулийн 26.1.17, 26.8-д заасан үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтны цалин хөлс, үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.

26.7.Энэ хуулийн 21.1, 21.2, 21.3, 21.4, 21.5, 21.6, 26.2 дахь хэсэгт болон 26.1.7, 26.1.9, 26.1.13, 26.1.17-д заасан хөнгөлөлт, үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох зорилгоор Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.

26.8.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих төвийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэх зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлнэ.”

4/26 дугаар зүйлийн 26.1.17, 26.1.18 дахь заалт:

“26.1.17.хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх;

26.1.18.хөдөө орон нутгаас аймгийн төв, нийслэл Улаанбаатар хот, хотод бүх шатны боловсролын байгууллагад суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч тус бүрд ирж, очих тээврийн зардлыг жилд нэг удаа автозамын болон агаарын тээврийн тарифт үнээр тооцож нөхөн олгох;”

5/37 дугаар зүйлийн 37.10 дахь хэсэг:

37.10.Энэ хуулийн 37.9-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээнд үндэслэн хувийн цогц төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсрол, сэргээн засах болон нийгмийн оролцоог дэмжих чадваржуулах үйлчилгээ, асаргааны хувилбарт болон хувийн туслах үйлчилгээ, урт хугацааны сэргээн засалтын үйлчилгээ тохирох хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний дэмжлэгт холбон зуучлах, хэрэгжилтэд хяналт тавина.

2 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.7 дахь заалтын “дотоодын” гэсний өмнө “магадлан итгэмжлэгдсэн” гэж, 26 дугаар зүйлийн нэрийн болон мөн зүйлийн 26.1 дэх хэсгийн “хөнгөлөлт” гэсний дараа “, үйлчилгээ” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “насны” гэсний өмнө “хүртэлх” гэж, мөн зүйлийн 37.5 дахь хэсгийн “32.2.2” гэсний дараа “37.9” гэж, мөн зүйлийн 37.5 дахь хэсгийн “аргачлалыг” гэсний дараа “37.9-д заасан бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх шалгуур, аргачлалыг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/26 дугаар зүйлийн 26.1.7 дахь заалт:

26.1.7.Магадлан итгэмжлэгдсэн сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд эрхийн бичгийг жишиг үнийн дагуу тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

2/32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэг:

“32.8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй /нийслэлд зориулалтын картаар/ зорчих бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийтийн тээврээр зорчсон төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ.”

3/37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсэг:

“37.9.Энэ хуулийн 37.2.2-т заасан зөвлөлөөс гаргасан дүгнэлтэд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан зөвлөл аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дэргэд ажиллана.”

4 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл” гэснийг “нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүн” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа сувилгааны болон бусад туслах хэрэгслээр” гэснийг “нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүнээр” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “цэцэрлэг, сургуульд” гэснийг “бүх шатны боловсролын байгууллага, дэмжих төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ болон бусад нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний байгууллагад” гэж, мөн зүйлийн 26.1.9 дэх заалтын “рашаан” гэснийг “магадлан итгэмжлэгдсэн” гэж, мөн зүйлийн 26.1.12 дахь заалтын “50” гэснийг “100” гэж, мөн зүйлийн 26.1.16 дахь заалтын “асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг” гэснийг “тохиолдолд живхний үнийн хөнгөлөлт” гэж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийн “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд” гэснийг “энэ хуулийн 26.1.17-д заасан” гэж, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6” гэснийг “21.4, 21.5, 26.1.5, 26.1.7, 26.1.9, 26.1.10, 26.1.12, 26.1.13, 26.1.15, 26.1.16, 26.1.18-д” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын” болон “Тэтгэмжийн даатгалын” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.6, 26.1.11, 26.1.14 дэх заалтыг тус тус хүчингүй болгосугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг:

“7.9.Энэ хуулийн 4.1.9-д заасан асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын асаргааны ажилтныг сургах сургалтын хөтөлбөрийн загварыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.12-т заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөн хуулийн 9.1-д заасан сургалтын байгууллага хэрэгжүүлж, сургалтын байгууллагыг төгсөгчид боловсролын баримт бичиг олгоно.”

2/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Энэ хуулийн 10.1.2-т заасан сувиллын хөнгөлөлтийн жишиг үнийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.”

3/14 дүгээр зүйлийн 14.5.6 дахь заалт:

“14.5.6.бүх шатны Засаг дарга нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мод тарих, мэдлэг туршлагыг залуу хойч үед өвлүүлэх үйл ажиллагааг дэмжих, аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх.”

4/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл.Орон тооны бус ахмад настны бодлогын зөвлөл.

15¹.1.Ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Орон тооны бус ахмад настны бодлогын зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулж болно.

15¹.2.Зөвлөлийн үйл ажиллагаа нь улс төрөөс ангид байх ба бүх талын төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг Засгийн газар батална.

15¹.3.Зөвлөлийн ажлын албаны үүргийг ахмад настны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

15¹.4.Зөвлөл нь аймаг, нийслэл, дүүрэгт салбар зөвлөлтэй байх бөгөөд салбар зөвлөлийг Засаг дарга тэргүүлнэ.

15¹.5.Энэ хуулийн 15¹.1-д заасан зөвлөл болон 15¹.4-т заасан салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал, цалин хөлс олгохгүй.”

2 дугаар зүйл.Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.10, 7.2.11 дэх заалтын “сум, хорооны” гэсний дараа “халамжийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “10.1.4-т” гэсний өмнө “10.1.2” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “настанд” гэсний дараа “тухайн нутаг дэвсгэрт байрлах” гэж, мөн заалтын “хэмжээг” гэсний дараа “тогтмол” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “хэрэгжүүлэх” гэсний дараа, мөн 14.5.3 дахь заалтын “уламжлах” гэсний дараа “харьяа байгууллагад энэ хуулийн 14.7-д заасан Ахмадын сан байгуулан ажиллуулах, мөн хуулийн 11.1.1-д заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах” гэж тус тус, 14.5.5 дахь заалтын “тусгах” гэсний дараа “энэ чиглэлээр иргэн, хуулийн этгээдийн гаргасан санал санаачилгыг дэмжин хамтран ажиллах.” гэж, нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“8.1.1.хөл, гарын хиймэл эрхтэн, хиймэл шүд, сонсох, харах эрхтний болон нэн шаардлагатай тусгай хэрэгсэл худалдан авсан зардлын үнийн хөнгөлөлтийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 30.1-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөлийн шийдвэрээр 3 жилд нэг удаа эрүүл мэндийн даатгалын сангаас олгох.

13.5.Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.5, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ болон 7.1.7-д заасан асаргааны хувилбарт үйлчилгээний байгууллагын ажилтны цалин хөлс, үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.”

4 дүгээр зүйл.Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт заасан насанд хүрсэн” гэж, 8.1.2 дахь заалтын “амралт, сувиллын газарт” гэснийг “ахмадын зориулалттай амралтын газарт” гэж, 8.2 дахь хэсгийн “амралт, сувиллын газрын” гэснийг “ахмадын зориулалттай амралтын газрын” гэж, 14.1 дэх хэсгийн “ахмад настны” гэснийг “энэ” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 болон 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалтаас “төрөлжсөн” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтаас “7.1.8” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтаас “тээврийн хэрэгслийн нэг талын зардал” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгээс “8.1.3”, “10.1.2”, “10.1.5” гэснийг, 13.6 дахь хэсгээс “7.1.8” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Ахмад настны тухай хуулийн дугаар зүйлийн 8.1.3, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

1/35 дугаар зүйлийн 35.2.7, 35.2.8, 35.2.9 дэх заалт:

“35.2.7.Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.6, 18.13, 20.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам;

35.2.8.Орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх журам;

35.2.9.Нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд нийтийн халуун усны үйлчилгээ, усны үйлчилгээний төлбөрийн дэмжлэг олгох, санхүүжүүлэх журам.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтын “3.1.2” гэснийг “4.1.15” гэж, мөн заалтын “туслалцаа” гэснийг “үйлчилгээ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт:

“15.1.15. Нийгмийн халамжийн тухай хуулийн 4.1.2-т заасан асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгж.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалтын “төв” гэсний дараа “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын дэргэдэх сэргээн засах нэгж”, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн “төвд” гэсний дараа “энэ хуулийн 15.1.15-д заасан нэгжид” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.21 дэх хэсгийн “настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд” гэснийг “настны хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг болон” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалт:

“13.3.3.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын дэргэдэх сэргээн засах нэгж.”

2/14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт:

“14.2.8.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.15-д заасан нэгж.”

2 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн гарчгийн “төв” гэсний дараа “нэгж, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгж,” гэж, мөн зүйлийн 19.1 дэх хэсгийн “сэргээн засах төв” гэсний дараа “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын дэргэдэх сэргээн засах нэгж, мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.15-д заасан асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгж,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 дахь заалтын “засахын дагнасан” гэснийг “засах” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17, 9.1.18, 9.1.19 дэх заалт:

“9.1.16.Нийгмийн халамжийн тухай хуулийн 15.1-д заасан өрхийн 0-6 хүртэлх насны хүүхдэд эм, бичил тэжээлийн, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн үнийн хөнгөлөлт;

9.1.17.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан өндөр болон зарим дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн хөнгөлөлтийг;

9.1.18.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүндэт донорын сувиллын үнийн хөнгөлөлт;

9.1.19.Нийгмийн халамжийн тухай хуулийн 15.1-д заасан өрхийн согтуурах мансуурах донтой иргэний донтолтыг бууруулах эмийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал.”

2/9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг:

“9.7.Энэ хуулийн 9.1.17, 9.1.18-д заасан тусламж, үйлчилгээний зардлын нэмэлт төлбөрийг нийгмийн халамжийн сангаас эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн төсөвт шилжүүлэн тусгаж эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “туслалцаа” гэснийг “үйлчилгээ”, “22 дугаар” гэснийг “13 дугаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг нэмсүгэй:

1/43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг:

“43.6.Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, болон 18 ба түүнээс дээш насны хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөхтэй холбоотой шийдвэр гаргахдаа хүний оролцоог багасгаж, цахим системээр санамсаргүй хуваарилах аргыг хэрэглэнэ.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “хүний” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй эсэх, түүний ангилал, зэрэг,” гэж, 21 дүгээр зүйлийн 21.22 дахь хэсгийн “эх, эсхүл эцэг” гэсний дараа “асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж, 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсгийн “Даатгуулагч,” гэсний дараа “болон 18 ба түүнээс дээш насны” гэж, “хүний” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй эсэх, түүний ангилал, зэрэг,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй.

1/10.31 дүгээр зүйл:

“10.31 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн тухай хууль зөрчих

1.Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглаж, зарцуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн үйлдэл, үйл ажиллагааны чадамж, асаргаа шаардлагатай эсэх, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг буруу тогтоосон, эсхүл тогтоогоогүй Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн гишүүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй болон асаргаа шаардлагатай эсэхийг буруу тогтоосон, эсхүл тогтоогоогүй Эрүүл мэндийн тухай хуулийн 16.21-д заасан Эмнэлэг, хяналтын комиссын гишүүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэх, асаргаа шаардлагатай эсэхийг буруу тогтоосон, эсхүл тогтоогоогүй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1-д заасан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хуурамч баримт бичиг бүрдүүлэн нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, зардлыг үндэслэлгүйгээр илүү тогтоолгон авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг үндэслэлгүйгээр устгасан, засварласан, хуурамч мэдээлэл оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бус үйлдэл гаргаснаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Нийгмийн халамжийн тухай хуулийн 37.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн иргэнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

1/6 дугаар зүйлийн 67 дахь хэсэг:

“6.67.Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч болон нийгмийн халамжийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.31 дүгээр зүйлд заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 18.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтын “нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг” гэснийг “Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн арга хэмжээ болон Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан дэмжлэгийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“22.1.Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам болон амьд донор болон цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд жилд нэг удаа Засгийн газраас тогтоосон жишиг үнийн дагуу хөнгөлөлттэй үнээр сувилуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“32.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 15.1-д заасан өрхийн согтуурах мансуурах донтой иргэний донтолтыг бууруулах эмийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19.1.5-д заасны дагуу эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.”

2/32¹ дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйлчилгээ

“32¹.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 15.1-д заасан нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай өрхийн согтуурах мансуурах донтох өвчтэй иргэнд мөн хуулийн 15.3, 18.14-т заасны дагуу үзүүлэх үйлчилгээний зардлыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангаас нийгмийн халамжийн санд шилжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмсүгэй.

1/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

“8.3.Сэтгэцийн эмгэгтэй хүний эрүүл мэндийн байдал, онцлог хэрэгцээг харгалзан асрамжийн газрыг төрөлжүүлэн үзүүлэх ба Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.2.5-д заасан үйлчлүүлэгчийн хувьсах зардлыг нийгмийн халамжийн сангаас тухайн байгууллагад олгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.8 дахь заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.3.8 дахь заалт:

“3.3.8.Нийгмийн халамжийн тухай хуулийн 4.1.9-д заасан зорилтот өрх, иргэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2-т заасан хүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлэх үйлчилгээг тогтоосон жишиг үнэ болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нөхцөл шалгуур, сонгон шалгаруулах журмын дагуу худалдан авах ажиллагаа;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд доор дурдсан агуулга заалт нэмсүгэй.

1/3 дугаар зүйлд 3.1.24 дэх заалт:

“3.1.24.”усны үйлчилгээний дэмжлэг” гэж хэрэглэгчийн төлөх цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрөөс хасагдах дүнг.”

2/7 дугаар зүйлд 7.1.3 дахь заалт:

“7.1.3.Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь энэ хуулийн 10.1.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос баталсан усны үйлчилгээний тарифт үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай хэрэглэгчид олгох усны үйлчилгээний дэмжлэгийг орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгана.”

3/8 дугаар зүйлд 8.1.8 дахь заалт:

“8.1.8.Зохицуулах хорооны тогтоосон тарифын дагуу тооцсон төлбөрөөс энэ хуулийн 3.1.24-т заасан хөнгөлөлтийг олгох;”

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “журам” гэсний дараа “болон Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.6-д заасан усны үйлчилгээний төлбөрийн дэмжлэг, хамрах хүрээг тооцох аргачлал батлах,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн “7.1.3” гэснийг “7.1.4” гэж, “8.1.8” гэснийг “8.1.9” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2 дахь заалтын “эрхийн бичгийн” гэсний дараа “жишиг үнэ” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “улсын” гэсний дараа “болон орон нутгийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.2.Энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд, хувийн хэвшлийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд оршин суугаа харьяаллын аймаг, нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь нэмэгдлийг сар бүр, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөнгөлөлтийг тухай бүр ахмад настны арилжааны банкн дахь нэрийн дансанд шилжүүлнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд доор дурдсан агуулгатай 23.1.16 дахь заалт нэмсүгэй:

“23.1.16.Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.23, 17.3, 20.6.3-т заасан зардлыг санхүүжүүлэх.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт:

“10.1.6.төрөөс үзүүлж байгаа эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний бүртгэл, мэдээллийг цахимжуулах, үйлчилгээний давхардлыг арилгах, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зөрчлийг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох зорилгоор биометрик мэдээллийг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... сарын
...-ны өдөр

Улаанбаатар хот

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2.4 дэх заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт:

“9.2.4. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг